



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,
Утас/факс: (976-11) 329084
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2014. 02. 27 № 11719

ганий _____-ны № _____-т

УИХ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНД

Монгол Улсын арилжааны даатгалын байгууллагуудын 2013 оны 4 дүгээр улирлын санхүү, даатгалын үйл ажиллагааны нэгдсэн танилцуулгыг хавсралтаар хүргүүлж байна.

/Хавсралт, хуудас/



000321

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

- 1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
- 1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ
- 1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 1.6 ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЫЦАА
- 1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА
- 1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 1.9 ДАВХАР ДААТГАЛ
- 1.10 АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

ХОЁРДУГААР БҮЛЭГ. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

- 2.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ
- 2.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, ДАВХАР ДААТГАЛ
- 2.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГТА АЖИЛЛАГАА, НӨӨЦ САН

ГУРАВДУГААР БҮЛЭГ.ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

- 3.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ
- 3.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

ДҮГНЭЛТ

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2013 ОНЫ САНХҮҮ,
ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

1. ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2013 оны жилийн эцсийн байдлаар даатгалын зах зээл дээр ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 компани, 213 даатгалын салбар, 3187 даатгалын төлөөлөгч, 20 даатгалын зуучлагч компани, 14 даатгалын хохирол үнэлэгч компани, 15 актуарч, нийт 3253 тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулсан байна. Эдгээрээс “Монгол даатгал” ХХК гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай, “Ард даатгал” ХХК, “Ган зам даатгал” ХХК-иуд хамтарсан хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт - 1

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

№		2009	2010	2011	2012	2013
1	Даатгагч	18	17	17	18	17
2	Даатгалын компанийн салбар	129	138	138	188	213
3	Даатгалын төлөөлөгч	1676	2061	2057	2357	3187
4	Даатгалын зуучлагч	5	9	8	17	20
5	Даатгалын хохирол үнэлэгч	2	6	9	9	14
6	Актуарч	10	12	13	18	15
БҮГД		1711	2105	2104	2419	3253

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор “Жонон даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргасан байна.

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо 2013 оны 4 дүгээр улирлын байдлаар 2012 оны мөн үеийнхээс 1.34 дахин нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд Хорооны 2013 оны 92 дугаар тогтоолоор “Эс ай би эс” ХХК-д, 175 дугаар тогтоолоор “Хадгаламж банк” ХХК-д, 199 дүгээр тогтоолоор “Эй эс ай би” ХХК-д, 296 дугаар тогтоолоор “Төрийн банк” ХХК-д, 461 дүгээр тогтоолоор “Хүннү сиэл” ХХК-д тус тус даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна. Мөн Хорооны 2013 оны 292 дугаар тогтоолоор “Жомолхари” ХХК, 295 дугаар тогтоолоор “Хадгаламж банк” ХХК-ийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон байна.

Хорооны 2013 оны 28 дугаар тогтоолоор “Ашид билгүүн” ХХК, 187 дугаар тогтоолоор “Юу энд эн” ХХК, 224 дүгээр тогтоолоор “Тэгш сонголт эстимэйт” ХХК, 367 дугаар тогтоолоор “Фэйр валуэшн” ХХК, 462 дугаар тогтоолоор “Арга билэг эстимэйт” ХХК-д тус тус даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.



1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

Тайлант оны 4 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн нийт хөрөнгийн хэмжээ 126.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх 2012 оны мөн үетэй харьцуулахад 18.8 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилд 3.1 дахин нэмэгдсэн дүнтэй байна. Эдгээрээс гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хөрөнгийн хэмжээ 20.3 хувийг эзэлж байна.

График – 2



Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2013 оны 4 дүгээр улиралд 109.6 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 86.7 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 16.8 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 13.3 хувийг эзэлж байгаа бол 2012 оны мөн үед эргэлтийн хөрөнгө 88.7 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 82.5 хувь, эргэлтийн бус хөрөнгө 18.9 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 17.5 хувийг эзэлж байсан байна.

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	12.12.31		13.12.31		Өсөлт/ бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Эргэлтийн хөрөнгө	88 721,80	82,5	109583,3	86,69	20 861,50	1.80
Эргэлтийн бус хөрөнгө	18 883,20	17,5	16819,9	13,31	- 2 063,30	(1.80)
Нийт хөрөнгө	107 605,00	100	126403,2	100.00	18 798,20	

Тайлант оны эцсийн байдлаар эргэлтийн хөрөнгийн 64.8 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 22.0 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 10.37 хувийг дансны авлага, үлдэх 2.83 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад эргэлтийн хөрөнгө 0.31 пунктээр, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 6.34 пунктээр тус тус өсч, дансны авлага 0.73 пунктээр, богино хугацаат хөрөнгө оруулалт 5.92 пунктээр тус тус буурсан байна.

Эргэлтийн хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 20861.4 сая төгрөгөөр өссөн нь Хорооны 2012 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох” тухай тогтоол хэрэгжиж байгаатай холбоотой юм.

Эргэлтийн хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2012		2013		Өөрчлөлт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	51870,4	58,46	74791,8	64,80	22921,4	6,34
Богино хугацаат хөрөнгө оруулалт	24772,2	27,92	15168,4	22,00	-9603,8	-5,92
Дансны авлага	9847,9	11,10	16601,3	10,37	6753,4	-0,73
Бусад эргэлтийн хөрөнгө	2231,4	2,52	3021,8	2,83	790,4	0,31
Эргэлтийн хөрөнгийн дүн	88721,9	100	109583,3	100	20861,4	

2013 оны жилийн эцсийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь харьцуулахад “Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК-ийн хөрөнгө даатгагчдын нийт хөрөнгийн 30.2 хувийг эзэлж, “Гэр даатгал” ХХК-ийн 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө хамгийн бага буюу зах зээлийн нийт хөрөнгийн 2.3 хувийг эзэлж байна.

/сая төгрөгөөр/


№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	7 128,3	5,6
2	Бодь даатгал ХХК	12 551,0	9,9
3	Ган зам даатгал ХХК	4 097,6	3,2
4	Гэр даатгал ХХК	2 865,6	2,3

5	Мандал женерал даатгал ХХК	8 822,3	7,0
6	МИГ даатгал ХХК	7 522,5	6,0
7	Монгол даатгал ХХК	25 635,5	20,3
8	Моннис даатгал ХХК	4 482,4	3,5
9	Монре даатгал ХХК	4 375,1	3,5
10	Мөнх даатгал ХХК	3 503,7	2,8
11	Номин даатгал ХХК	6 611,1	5,2
12	Нэйшил лайф даатгал ХХК	5 626,7	4,5
13	Практикал даатгал ХХК	7 867,8	6,2
14	Соёмбо даатгал ХХК	6 746,8	5,3
15	Тэнгэр даатгал ХХК	9 743,2	7,7
16	УБ хотын даатгал ХХК	4 829,5	3,8
17	Хаан даатгал ХХК	3 994,1	3,2
	Дүн	126 403,2	

1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 5 жилийн оны эцсийн байдлаар харьцуулж харахад дараах байдалтай байна.

График – 3



Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2009 оны 4 дүгээр улиралд 60.3 хувийг эзэлж байсан бол 2010 оны 4 дүгээр улиралд 51.4 хувь, 2011 оны 4 дүгээр улиралд 44.5 хувь, 2012 оны мөн үед 44.84 хувь эзэлж, тайлант 45.4 хувь эзэлж байгаа нь Хорооны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д Хорооны 2012 оны 389 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдож тодорхой пунктээр нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2008 оноос хойш тогтвортой өсч ирсэн байна. Харин өр төлбөрийн дүн өмнөх онд 4.85 хувь байсан бол тайлант онд 5.0 хувь болж нэмэгдсэн байна.

Эзэмшигчдийн өмч

Хүснэгт - 5

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2012		2013		Өөрчлөлт	
Өр төлбөр	5 217,00	4,85	6 320,40	5,00	1 103,40	0,15
Нөөц сан	48 252,60	44,84	58 769,80	46,49	10 517,20	1,65
Эзэмшигчийн өмч	54 135,40	50,31	61 313,10	48,51	7 177,70	- 1,80
Нийт дун	107 605,00	100,00	126 403,30	100,00	18 798,30	-

Тайлант үеийн эзэмшигчдийн өмчийн дүн сүүлийн 5 жилийн байдлаар тогтвортой өсч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 18798.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж ирсэн нь даатгалын компаниудын цэвэр ашгийн өсөлттэй холбоотой байна.

1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2013 оны эцэст 93897.4 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.2 дахин өссөн байна.

Тайлант онд ердийн даатгалын компаниуд 92871.8 сая төгрөгийн, урт хугацааны даатгалын компани 1025.6 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлого тус тус төвлөрүүлсэн байна. Ердийн даатгалын компанийн хураамжийн орлого өмнөх оны мөн үеийнхээс 14663.8 сая төгрөгөөр буюу 1.2 дахин, урт хугацааны даатгалын орлого 230.0 сая төгрөгөөр буюу 1.3 дахин тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээний хэмжээ 31508.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын орлого нийт даатгалын хураамжийн орлогын 26.6 хувийг эзэлж байна.

Даатгалын хэлбэрээр 2013 оны 4 дүгээр улирлын нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.47 дахин, хөрөнгийн даатгал 1.37 дахин, автотээврийн хэрэгслийн даатгал 1.06 дахин, ачааны даатгал 1.3 дахин, барилга угсралтын даатгал 2.35 дахин, мал амьтадын даатгал 1.75 дахин, хугацаат амьдралын даатгал 1.16 дахин, тэтгэврийн даатгал 1.64 дахин, эрүүл мэндийн даатгал 1.57 дахин тус тус өсч, агаарын хөлгийн даатгал 18 хувиар, хариуцлагын даатгал 6 хувиар, санхүүгийн даатгал 25 хувиар, хуримтлалын даатгал 17 хувиар буурсан байна.


Хүснэгт - 6
/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	12.12.31	13.12.31	Өөрчлөлт /+,/-/
	Даатгалын нийт	Даатгалын нийт хураамжийн орлого	

	хураамжийн орлого (сая.төг)	(сая.төг)	
1.1 Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	6201	9 107,10	1,47
1.2 Хөрөнгийн даатгал	18716,6	25 628,00	1,37
1.3 Автомобийн хэрэгслийн даатгал	15342,9	16 332,70	1,06
1.4 Ачааны даатгал	1392,9	1 810,20	1,30
1.5 Барилга угсралтын даатгал	1756,1	4 122,20	2,35
1.6 Газар тариалангийн даатгал		-	-
1.7 Мал амьтдын даатгал	441,1	770,80	1,75
1.8 Агаарын хөлгийн даатгал	8570	7 044,40	0,82
1.9 Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	0	370,7	-
1.10 Хариуцлагын даатгал	7514,3	7 069,80	0,94
1.11 Санхүүгийн даатгал	1975	2 576,80	1,30
1.12 Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	16298,1	15154,9	0,93
1.13 Зээлийн даатгал		2 191,70	-
1.14 Итгэлцлийн даатгал		6,60	-
1.15 Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал		-	-
1.16 Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал		-	-
1.17 Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал		686,00	-
2.1. Хугацаат амьдралын даатгал	326,7	379,30	1,16
2.3. Хуримтлалын даатгал	125,3	103,70	0,83
2.4 Тэтгэврийн даатгал	35,3	57,90	1,64
2.5. Эрүүл мэндийн даатгал	308,2	484,70	1,57
	79 003,50	93 897,40	1,19

График – 4

Даатгалын хураамжийн орлого




2003 оноос хойш 2013 он хүртэл нийт орлогын өсөлт 87.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт харагдаж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин нэмэгдсэн нь 2012 оноос “Жолоочийн даатгалын тухай хууль” батлагдаж хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой бөгөөд албан журмаар даатгуулах даатгуулагчдын тоо нэмэгдэж, даатгалын хураамжийн орлогыг сүүлийн жилийн дундажаас огцом өссөн байна. Түүнчлэн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын өсөлтийг дагаж авто тээврийн хэрэгслийн даатгал өндөр өсөлттэй гарсан байна. Даатгалын хураамжийн орлогын өсөлт мөн инфляци, үнийн өсөлтүүд нөлөөлсөн гэж үзэж болно.

График - 5




Даатгалын нийт хураамжийн орлогыг ДНБ-д эзлэх хувиар харуулахад өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.03 пункттээр буурсан байна.

График – 6



Нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого нь сүүлийн жилүүдэд өссөн байдалтай харагдаж байна.



Тайлант онд нийт хураамжийн орлого 93.9 тэрбум төгрөг болсон бөгөөд нэг хүнд ногдох хураамжийн орлого 32.4 мянган төгрөгт хүрчээ. Энэ үзүүлэлт 2003 оноос хойш даруй 15.2 дахин, өмнөх оны мөн үеийнхээс 3.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2013 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 26459.3 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон. Гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай компанийн олгосон даатгалын нөхөн төлбөр нийт нөхөн төлбөрийн 39.2 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.21 дахин, хөрөнгийн даатгал 1.3 дахин, автотээврийн хэрэгслийн даатгал 1.13 дахин, ачааны даатгал 1.3 дахин, мал амьтадын даатгал 2.03 дахин, хариуцлагын даатгал 1.11 дахин, жолоочийн хариуцлагын албан

журмын даатгал 2.2 дахин, хуримтлалын даатгал 1.0 дахин, эрүүл мэндийн даатгал 2.14 дахин тус тус өсч, агаарын хөлгийн даатгал 74 хувиар, санхүүгийн даатгал 25 хувиар, хугацаат амьдралын даатгал 8 хувиар, тэтгэврийн даатгал 13 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт - 7
/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	12.12.31	13.12.31	Өөрчлөлт /+/-
	Даатгалын нийт нөхөн төлбөр (сая.төг)	Даатгалын нийт нөхөн төлбөр (сая.төг)	
1.1 Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1781,3	2 155,50	1,21
1.2 Хөрөнгийн даатгал	1830,8	2 377,30	1,30
1.3 Автотээврийн хэрэгслийн даатгал	6568,4	7 442,90	1,13
1.4 Ачааны даатгал	195,3	260,20	1,33
1.5 Барилга угсралтын даатгал		79,80	
1.6 Газар тариалангийн даатгал			
1.7 Мал амьтдын даатгал	28,4	57,70	2,03
1.8 Агаарын хөлгийн даатгал	29,3	7,70	0,26
1.9 Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал		16,2	-
1.10 Хариуцлагын даатгал	284,9	315,80	1,11
1.11 Санхүүгийн даатгал	1208,4	911,10	0,75
1.12 Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	4790,9	10643,7	2.2
1.13 Зээлийн даатгал		1 932,10	
1.14 Итгэлцлийн даатгал			
1.15 Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал			
1.16 Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			
1.17 Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			
2.1. Хугацаат амьдралын даатгал	56,5	52,00	0,92
2.3. Хуримтлалын даатгал	78,5	78,40	1,00
2.4 Тэтгэврийн даатгал	6,9	6,00	0,87
2.5. Эрүүл мэндийн даатгал	57,3	122,90	2,14
	16 916,90	26 459,30	1,56


2013 онд даатгагчийн нөхөн төлбөр 26.5 тэрбум төгрөгт хүрч сүүлийн 10 жилийн өмнөх үеэс 25.2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Энэ үзүүлэлтээс харахад нөхөн төлбөр тогтмол өссөн үзүүлэлт ажиглагдаж байна.



График - 7

1.6 ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

2013 оны 4 дүгээр улиралд даатгалын хохирлын харьцаа даатгалын салбарын дүнгээр 42.0 хувь болж 5 жилийн өмнөх үеийнхээс 8.5 пунктээр, өмнөх оны мөн үеэс 7.1 пунктээр тус тус нэмэгдсэн байна.



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирлын харьцаагаар нь харуулахад 2013 оны 4 дүгээр улиралд “Номин даатгал” ХХК 55.7 хувь буюу хамгийн өндөр хувьтай байна.

Хүснэгт - 8

№	Даатгагчийн нэр	2012	2013	Өөрчлөлт /пункт/
1	Ард даатгал ХХК	37,8	41,1	3,28

2	Бодь даатгал ХХК	32,0	34,4	2,40
3	Ган зам даатгал ХХК	7,8	11,4	3,55
4	Мандал даатгал ХХК	18,5	37,6	19,11
5	МИГ даатгал ХХК	38,0	45,4	7,45
6	Монгол даатгал ХХК	41,9	50,2	8,24
7	Гэр даатгал ХХК	40,0	36,7	(3,29)
8	Моннис даатгал ХХК	13,5	12,3	(1,26)
9	Мөнх даатгал ХХК	15,4	26,5	11,06
10	Номин даатгал ХХК	36,8	55,7	18,93
11	Нэйшил лайф даатгал ХХК	27,0	25,3	(1,72)
12	Практикал даатгал ХХК	31,1	46,4	15,33
13	Тэнгэр даатгал ХХК	35,6	36,9	1,33
14	Соёмбо даатгал ХХК	39,9	48,5	8,62
15	Монре даатгал ХХК	23,9	46,6	22,66
16	УБ хотын даатгал ХХК	27,8	27,8	-
17	Хаан даатгал ХХК	3,59	22,99	19,40
	Нийт дүн	34.9	42.0	7.1

2013 онд даатгалын компанийн даатгалын хохирлын харьцааг өмнөх оныхтой харьцуулахад “Ард даатгал” ХХК 3.28 пунктээр, “Бодь даатгал” ХХК 2.40 пунктээр, “Ганзам даатгал” ХХК 3.55 пунктээр, “Мандал женерал даатгал” ХХК 19.11 пунктээр, “Миг даатгал” ХХК 7.45 пунктээр, “Монгол даатгал” ХХК 8.24 пунктээр, “Мөнх даатгал” ХХК 11.06 пунктээр, “Номин даатгал” ХХК 18.93 пунктээр, “Практикал даатгал” ХХК 15.33 пунктээр, “Тэнгэр даатгал” ХХК 1.33 пунктээр, “Соёмбо даатгал” ХХК 8.62 пунктээр, “Монре даатгал” ХХК 22.66 пунктээр, “Хаан даатгал” ХХК 22.6 пунктээр тус тус нэмэгдэж, “Гэр даатгал” ХХК 3.29 пунктээр, “Моннис даатгал” ХХК 1.26 пунктээр, “Нэйшил лайф даатгал” ХХК 1.72 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

2013 оны 4 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 5287.8 сая төгрөг болсон нь өмнөх жилийн мөн үеийнхээс 2892.4 сая төгрөгөөр буурсан байна.


Хүснэгт – 9

№	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эзлэх хувь	Ашигт ажиллагааны түвшин
1	Ард даатгал ХХК	2 574,1	54,2	41,4
2	Бодь даатгал ХХК	(1 776,9)	-37,4	-20,3
3	Ган зам даатгал ХХК	530,5	11,2	99,4
4	Мандал женерал даатгал ХХК	706,6	14,9	25,5
5	МИГ даатгал ХХК	429,0	9,0	8,8
6	Монгол даатгал ХХК	738,4	15,5	4,8
7	Гэр даатгал ХХК	177,7	3,7	39,8
8	Моннис даатгал ХХК	280,5	5,9	55,7
9	Мөнх даатгал ХХК	112,5	2,4	11,5
10	Номин даатгал ХХК	190,0	4,0	5,1
11	Нэйшил лайф даатгал ХХК	(75,4)	-2,3	-7,4
12	Практикал даатгал ХХК	(40,8)	-0,9	-1,0
13	Тэнгэр даатгал ХХК	835,1	17,6	16,2
14	Соёмбо даатгал ХХК	70,5	1,5	1,6
15	Монре даатгал ХХК	140,4	3,0	7,9
16	УБ хотын даатгал ХХК	559,3	11,8	52,2

17	Хаан даатгал ХХК дүн	(699,0) 4 752,5	-14,7 100.0	-91,4
----	-------------------------	--------------------	----------------	-------

2013 оны 4 дүгээр улиралд “Бодь даатгал” ХХК 1776.9 сая төгрөг, “Нэйшил лайф даатгал” ХХК 75.4 сая төгрөг, “Практикал даатгал” ХХК 40.8 сая төгрөг, “Хаан даатгал” ХХК 699.0 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан ба энэ нь нийт даатгалын салбарын хуримтлагдсан ашгийг бууруулахад нөлөөлсөн байна.

График – 8



Даатгалын компаниудын хуримтлагдсан ашиг тайлант онд өмнөх оны мөн үеийнхээс 717.8 сая төгрөгөөр буурсан нь дүрмийн сангaa хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлж байгаатай холбоотой юм. Мөн алдагдалтай ажиллаж байгаа компаниудын хуримтлагдсан алдагдал нөлөөлж байна.


1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 5 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн. 2009 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын нөөц сангийн хэмжээ 24.7 тэрбум төгрөг байсан бол 2013 оны эцэст 57.3 тэрбум төгрөгт хүрч 5 жилийн өмнөх мөн үеийнхээс 2.3 дахин нэмэгдсэн байна.

График - 9

Даатгалын нөөц

тэрбум төг



1.9 ДАВХАР ДААТГАЛ

2013 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын компаниуд гадаадын давхар даатгагч нарт их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж, 26.0 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.2 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн дүнтэй гарсан байна.

График – 10



Хүснэгт - 10
/сая төгрөгөөр/

№	Компанийн нэр	2012		2013		Өөрчлөлт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Ард даатгал ХХК	3005,2	14,38	4233,8	16,30	1228,6	1,92
2	Бодь даатгал ХХК	6072,4	29,06	3308,9	12,74	-2763,5	-16,32
3	Тэнгэр даатгал ХХК	855,7	4,09	3100	11,93	2244,3	7,84
4	Практикал даатгал ХХК	746	3,57	170	0,65	-576	-2,92
5	Миг даатгал ХХК	1704	8,15	3162,2	12,17	1458,2	4,02

6	Монгол даатгал ХХК	4386,3	20,99	6387,7	24,59	2001,4	3,60
7	Номин даатгал ХХК	63,7	0,30	128,6	0,49	64,9	0,19
8	Нэйшил лайф даатгал ХХК	44,7	0,21	64,6	0,25	19,9	0,03
9	Мандал женерал даатгал ХХК	1417,9	6,78	3739,7	14,39	2321,8	7,61
10	Соёмбо даатгал ХХК	1266,2	6,06	316,4	1,22	-949,8	-4,84
11	Ган зам даатгал ХХК	170,5	0,82		0,00	-170,5	-0,82
12	Моннис даатгал ХХК	1099,7	5,26	1248,1	4,80	148,4	-0,46
13	Монре даатгал ХХК	65,8	0,31	120,1	0,46	54,3	0,15
Дүн		20898,1	100	25980,1	100	5082	0,00

Тайлант оны жилийн эцсийн байдлаар гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг 2012 оны мөн үеийнхтэй харьцуулахад давхар даатгалын хураамжийн хэмжээгээ “Ард даатгал” ХХК 1228.6 сая төгрөгөөр, “Тэнгэр даатгал” ХХК 2244.3 сая төгрөгөөр, “Миг даатгал” ХХК 1458.2 сая төгрөгөөр, “Монгол даатгал” ХХК 2001.4 сая төгрөгөөр, “Мандал женерал даатгал” ХХК 2321.8 сая төгрөгөөр, “Моннис даатгал” ХХК 148.4 сая төгрөгөөр, “Монре даатгал” ХХК 54.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, “Бодь даатгал” ХХК 2763.5 сая төгрөг, “Соёмбо даатгал” ХХК 949.8 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

2013 онд даатгалын компаниуд өөрсдийн хүлээсэн эрсдэлээ гадаадын давхар даатгагчид даатгуулах хандлага өсч өмнөх оны мөн үеийнхээс 1.25 дахин нэмэгдсэн байна

1.10 АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

Монгол Улсад автотээврийн хэрэгсэл болон жолоочийн тоо жилээс жилд өсөхийн хэрээр замын хөдөлгөөний нягтрал нэмэгдэж зам, тээврийн ослын тоо, иргэдэд учрах хохирлын хэмжээ нэмэгдсээр байна. Улсын их хурлаас албан журмын даатгалын анхны хэлбэр болгож тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч нь даатгалтай эсэхээс үл хамааран зам, тээврийн осолд өртсөн гуравдагч этгээд буюу амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэд, байгууллагуудад нөхөн төлбөр олгож, хариуцлагын даатгалын суурь амжилттай тавигдлаа.

Монгол улсад албан журмын даатгалын үйл ажиллагааг нийслэлд даатгалын 16 компани, орон нутагт даатгалын компанийн 213 салбар, даатгалын 2357 төлөөлөгч эрхлэн явуулж байна.

Тайлант онд жолоочийн даатгалаар нийт 15.1 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрч 10.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс хураамжийн орлого 1.1 тэрбум төгрөгөөр буурч, нөхөн төлбөр 5.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 367.7 мянган гэрээ байгуулагдсан байна. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо 19.6 мянга байна.

/сая төгрөгөөр/


№	Даатгалын компани	Даатгалын гэрээний тоо	Жолоочийн даатгалын хураамж	Олгосон нөхөн төлбөр	Нөхөн төлбөр авсан тоо
1	“Монре даатгал” ХХК	11,337	812,363,6	595.4	1,323
2	“Ард даатгал” ХХК	45,079	1,064.4	858.6	1,677
3	“Бодь даатгал” ХХК	42,913	1,650.7	1,803.8	2,867

4	"Мөнх даатгал" ХХК	4,704	176.6	200.9	687
5	"Миг даатгал" ХХК	46,426	1,855.5	1,028.3	2,120
6	"Соёмбо даатгал" ХХК	32,245	1,355.9	910.5	1,803
7	"Монгол даатгал" ХХК	88,948	3,614.5	2,208.5	4,829
8	"Тэнгэр даатгал" ХХК	25,032	1,062.8	838.8	1,777
9	"Номин даатгал" ХХК	21,244	1,258.8	1,048.1	574
10	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	43	17.1	3.8	8
11	"Гэр даатгал" ХХК	4,551	229.1	110.8	242
12	"Ган зам даатгал" ХХК	181	13.1	10.2	10
13	"Практикал даатгал" ХХК	15,915	1,200.1	661.5	1,010
14	"Моннис даатгал" ХХК	9,605	34.8	5.2	5
15	"Мандал женерал даатгал" ХХК	9,605	451.9	300.2	612
16	"Хаан даатгал" ХХК	9,931	356.7	58.2	143
Нийт		367,759	15,154.9	10,643.6	19,687

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2012	2013
	Нийт хураамжийн орлого	79,003.50	92,871.79
1	Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлого	16,298.10	15154.9
2	Даатгалын гэрээний тоо /ширхэгээр/	373,480.00	276,866.00
	Нийт нөхөн төлбөр	16,916.90	30,049.55
3	Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	4,790.90	10643.5
4	Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	9,521.00	19687

Тайлант оны жилийн эцсийн байдлаар улсын бүртгэлд бүртгүүлсэн нийт тээврийн хэрэгслийн тоо, оношилгоонд орсон тээврийн хэрэгслийн тоо, татвар төлсөн тээврийн хэрэгслийн тоо, жолоочийн даатгалын гэрээний тоо дараах байдалтай байна:




Жолоочийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан Даатгалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Албан журмын даатгагчдын холбоо байгуулагдаж, Жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн санг үнэн зөв бүрдүүлж, программ хангамжуудыг боловсруулж нэвтрүүлэх түүнийгээ суулган ажиллуулах сервер, сүлжээний тоног төхөөрөмжүүдийг бий болгон ажиллаж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

2.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Даатгалын зах зээл дээр “Нэйшнл лайф даатгал” ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагааг 2008 оноос хойш явуулж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар нийт хөрөнгийн хэмжээ 4491.0 сая төгрөгөөр буюу 5.0 дахин нэмэгдсэн байна. (График-9)

/сая төгрөгөөр/




Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин нэмэгдсэн байна.

2.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, ДАВХАР ДААТГАЛ

Урт хугацааны даатгалын компани 2014 оны 4 дүгээр улирлын байдлаар 1025.6 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 64.6 сая төгрөгийг давхар даатгагчид төвлөрүүлж, 259.3 сая төгрөгийг нөхөн төлбөрт төлжээ. Өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад даатгалын хураамжийн орлого 1.3 дахин, нөхөн төлбөр 1.3 дахин, давхар даатгал 1.4 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. (Хүснэгт-19)

Он	2009	2010	2011	2012	2013
Хураамжийн орлого	115.3	285.2	510.3	795.6	1025.6
Давхар даатгал		107.0	94.7	44.7	64.6
Нөхөн төлбөр		45.7	69.9	199.3	259.3

Тус компанийн даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөр 2010 оноос тогтмол нэмэгдэж ирсэн байна.



2.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА, НӨӨЦ САН

Урт хугацааны даатгагч нь 2008 оноос хойш алдагдалтай ажилласаар ирсэн бөгөөд нийт хуримтлагдсан алдагдлын хэмжээ одоогийн байдлаар 807.5 сая төгрөгт хүрчээ. Энэ нь нийт эзэмшигчийн өмчийн 20.0 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-20)

/сая төгрөгөөр/

Он	2009	2010	2011	2012	2013
Өр төлбөр	115.6	180.5	228.5	64.6	82.1
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1000.0	2000.0	3350.0	3350.0	4000.0
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-331.1	-474.6	-655.4	-770.3	-861.1
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-191.5	-142.5	-180.7	-114.9	-75.4
Нөөц сан	8.6	93.1	287.5	566.1	933.1

2010 оноос нөөц сангийн тайланг тайлагнасан байна.

Даатгалын нөөц	2009	2010	2011	2012	2013
Хувь оролцоотой гэрээний нөөц сан					
Хувь оролцоогүй гэрээний нөөц сан		46.9	287.5	566.1	933.1
Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан					
ДҮН	-	46.9	287.5	566.1	933.1

Даатгалын нөөц сан 2013 оны 3 дугаар улирлын байдлаар 810.7 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 354.4 сая төгрөгөөр өссөн бөгөөд өмнөх 4 жилийн мөн үеийнхээс 11.7 дахин нэмэгдсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

3.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант оны 4 дүгээр улиралд нийт 20 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нийт 1451.3 сая төгрөгийн даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн байна.

Хүснэгт - 15
/сая төгрөгөөр/

д/д	Компанийн нэр	12.12.31	13.12.31	Өсөлт бууралт
1	“Асимон брокерс” ХХК	128,8	141	1,09
2	“Аме” ХХК	29,4	213,1	7,25
3	“Ачит ундарга” ХХК	80,9	43	0,53
4	“Лоялти солюшн” ХХК	56,3	48,8	0,87
5	“Эм жи ай би” ХХК	16,6	0	-
6	“Ренессанс групп” ХХК	57,2	66,4	1,16
8	“Пийс офф лайф” ХХК	0	0,3	-
9	“Монголиан интернэшил брокерс” ХХК	20	0	Түдгэлзүүлсэн
10	“Юу ай би” ХХК	23	43,2	1,88
11	“Гэрэлт буян ундрах” ХХК	4,5	61,2	13,60
12	“Нэйшил эженси” ХХК	61,9	32,8	0,53

13	“Изи инвестмент” ХХК	-		Түдгэлэүүлсэн
14	“Си эн эн икс” ХХК	129,2	201,2	1,56
15	“Хаан банк” ХХК	-	93	
16	“Хас банк” ХХК	-	19,4	
17	“Эрсдлийн шийдэл” ХХК	-	487,9	
18	Төрийн банк ХХК			Үйл ажиллагаа явуулж эхлээгүй
19	“Эй эс ай би” ХХК			Үйл ажиллагаа явуулж эхлээгүй
20	Хүннү сэйл ХХК			Үйл ажиллагаа явуулж эхлээгүй
	Дүн	607,8	1451,3	843,5

Тайлант оны даатгалын зуучлалын хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Аме” ХХК 7.25 дахин, “Асимон брокерс” ХХК 1.09 дахин, “Ренессанс групп” ХХК 1.16 дахин, “Гэрэлт буян ундрах” ХХК 13.6 дахин, , “Юу ай би” ХХК 1.88 дахин, “Си эн эн икс” ХХК 1.56 дахин тус тус нэмэгдэж, “Лоялти солюшн” ХХК 13 хувиар, “Ачит ундарга” ХХК 57 хувиар, “Нэйшил эженсий” ХХК 57 хувиар тус тус буурсан байна.

Нийт хураамжийн орлогын 33.7 хувийг “Эрсдлийн шийдэл” ХХК нь дангаараа бүрдүүлсэн байна. Төрийн банк ХХК, Эй эс ай би ХХК, Хүннү сэйл ХХК-иуд үйл ажиллагаа явуулж эхлээгүй байгаа тул даатгалын зуучлалын орлого төвлөрүүлээгүй байна.

2.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын хохирол үнэлгээний орлого 462.4 сая төгрөг болсон байна.

Хүснэгт - 16

д/д	Компанийн нэр	12.12.31	13.12.31	Өсөлт бууралт /сая төгрөгөөр/
1	“Бест эстимэйт” ХХК	20,80	35,30	1,70
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	62,50	101,70	1,63
3	“Файн эстимэйт” ХХК	0,30	3,40	11,33
4	“Итгэлт эстимэйт” ХХК	38,90	53,30	1,37
5	“Мега марз” ХХК	-	10,20	0,00
6	“Вендо” ХХК	63,00	100,50	1,60
7	“Жи ай си си” ХХК	1,50	37,00	24,67
8	“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	0,50	1,00	2,00
9	Арвижих эстимэйт ХХК	9,90	39,30	3,97
10	Юу энд Эн		0,50	0,00
11	Тэгш сонголт эстимэйт		0,00	0,00
12	Ашид билгүүн ХХК		79,20	0,00
13	Арга билэг ХХК		0,1	
14	Фэйр валюшн ХХК			

				48,26
	Дүн	197,40	462,40	

2013 оны тайлант үеийн хураамжийн орлогын хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Бест эстимэйт” ХХК, 1.7 дахин, “Гэрэгэ эстимэйт” ХХК 1.63 дахин, “Файн эстимэйт” ХХК 11.3 дахин, “Итгэлт эстимэйт” ХХК 1.37 дахин, “Вендо” ХХК 1.6 дахин, “Жи ай си си” ХХК 24.67 дахин, “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК 2.0 дахин, “Арвижих эстимэйт” ХХК 3.97 дахин өссөн байна.

Тайлант хугацаанд “Тэгш сонголт эстимэйт” ХХК нь үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ

Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын салбарын хөгжлийн сүүлийн жилүүдийн динамик үзүүлэлтүүдийг харьцуулж үзэхэд даатгалын зах зээл эрчимтэй хөгжиж, даатгалын байгууллагуудын тоо, даатгагчдын нийт хөрөнгө, хураамжийн орлого, нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ өсч байгаа нь даатгалын зах зээлд оролцогч компаниуд, тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн үйл ажиллагааг туштай дэмжиж ажилласантай холбоотой боловч цаашид даатгалын зах зээлийн зохицуулалтыг боловсронгүй болгоход илүү анхаарал хандуулахыг шаардаж байна.

Тайлант онд даатгалын зуучлагч 3, даатгалын компанийн салбар 25, даатгалын хохирол үнэлэгч 3-аар нэмэгдсэн нь даатгалын салбарын дэд бүтэц хөгжиж, даатгалын зах зээлд оролцогдын хүрээ тэлж байгааг илтгэхийн хамт даатгуулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн Хорооны хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай болж байна.

Даатгалын байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад 2010 онд 56.7 тэрбум, 2011 онд 81.3 тэрбум, 2012 онд 107.6 тэрбум 2013 оны 4 дүгээр улиралд 126.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин өсч, даатгалын хураамжийн нийт орлого тайлант онд 93.9 тэрбум төгрөг болж өмнөх оныхоос 14.9 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин нэмэгдсэн нь даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлтүүд сайжирч байгааг илтгэн харуулж байна.

Даатгалын салбарын хэмжээнд тайлант хугацаанд даатгалын компанийдын олсон нийт хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 1.2 дахин өсч 93.9 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ нь хөрөнгийн даатгал, барилга угсралтын даатгал, гэнэтийн осол эмчилгээний даатгалын өсөлттэй холбоотой. Нөгөө талаас даатгалын хураамжийн орлогын өсөлт нь даатгалын нөхөн төлбөрийн өсөлтийг дагуулж байна. Тиймээс даатгалын хохирлын харьцаа сүүлийн жилүүдэд 30.0 хувийн дундаж үзүүлэлттэй байсан бол тайлант оны мөн үед 35.6 хувьд хүрсэн.

Даатгалын салбарын шинжилгээг тайлант оны мөн үеийн байдлаар санхүүгийн байдал, ашигт ажиллагааны түвшинд хийхэд дараах байдалтай байна.

- Хохирлын харьцаа= Төлсөн нэхэмжлэл/ОТхураамж: Салбарын дундаж үзүүлэлт 36.5 хувь байгаа бөгөөд нийт дүнгээрээ 43 хувьтай байна. Үүнээс хамгийн өндөр хохирлын харьцаа 56 хувьтай, хамгийн бага нь 12 хувьтай гарсан байна.

-Зардлын харьцаа=YA3/ОТхураамж: Боломжит түвшин 60хувь>=Зардлын харьцаа>=25 хувь байдаг бөгөөд дундаж үзүүлэлт 63 хувьтай байна. Компаниудын хувьд 52-1.48 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардал өндөртэй харуулж байна.

- Хосолсон харьцаа=Нөхөн төлбөр+УАЗардал/ОТхураамж: Боломжит түвшин 105 хувь>=хосолсон харьцаа>=85 хувь Энэ харьцаа нь 100 хувиас их нөхцөлд компанийн хөрөнгө оруулалтын ашигтай ажиллахыг шаарддаг. Дундаж 105 байгаа нь боломжит түвшинд хүрсэн байна.

- Өөрт үлдэх эрсдлийн харьцаа=Цэвэр хураамж/нийт хураамж: Боломжит түвшин 80 хувь>=хосолсон харьцаа>=40 хувь. Салбарын дундаж 71 хувьтай байна.

- Авлагын харьцаа=Хураамжийн авлага/Эзэмшигчийн өмч: Боломжит түвшин 20хувь>=авлагын сорил. Энэ үзүүлэлт нь 0.09 хувьтай байна.
- Өр төлбөрт эзлэх эзэмшигчийн өмчийн эзлэх: Боломжит түвшин нь эзэмшигчийн өмч>=25хувь бөгөөд дундаж үзүүлэлт 1.02 хувь байна.
- Хөрвөх чадвар=Эргэлтийн хөрөнгө/Нийт өр: Боломжит түвшин 95 хувь>=хөрвөх харьцаа. Салбарын дундаж 87 хувьтай байна
- ЭӨмч өгөөж=Цэвэр хураамж/ЭӨмч: Энэ нь салбарын дундаж үзүүлэлт 1.08 хувь байна.
- Нийт хөрөнгийн өгөөж=Даатгалын хураамж/Нийт хөрөнгө: Салбарын дундаж 73 хувьтай байгаа бөгөөд хамгийн их 1.42 хувь, хамгийн бага 14 хувийн үзүүлэлттэй хөрөнгийн өгөөжтэй байна.

ДААТГАЛЫН ГАЗАР